

ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ ОНОГДУУЛАХГҮЙ
БАЙХ, ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ЯВД-
ЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ БҮГД
НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэхийг эрмэлзэн БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар дараах зүйлийг хэлэлцэн тохиров.

1 дүгээр зүйл. Хамрагдах этгээд

Энэхүү Хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч хоёр улс буюу эдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна.

2 дугаар зүйл. Хамрагдах татварын төрлүүд

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Улс, түүний орон нутгийн эрх барих байгууллагуудаас орлогод оногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн оногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү Хэлэлцээрт хамрагдана.

2. Орлогын татвар гэж нийт орлого болон орлогын бүрэлдэхүүн хэсэгт оногдуулж буй бүх төрлийн татвар, үүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого, түүнчлэн хөрөнгийн үнэлгээний өсөлтийн орлогод оногдуулах татварыг хэлнэ.

3. Энэхүү Хэлэлцээрт дараах татварууд хамрагдана:

а/Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хувьд:

1. Хүн амын орлогод оногдуулах албан татвар;
2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн орлогод оногдуулах татвар;
3. Гадаадын аж ахуйн нэгжийн орлогод оногдуулах татвар;
4. Орон нутгийн орлогын татвар/цаашид "Монголын татвар" гэнэ/

б/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд:

1. Хүн амын орлогод оногдуулах албан татвар;
2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн болон гадаадын аж ахуйн нэгжийн орлогод оногдуулах татвар;
3. Орон нутгийн орлогын татвар/цаашид "Хятадын татвар" гэнэ/
4. Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш шинээр нэмэгдсэн буюу өөрчлөгдсөн татварууд нь 3 дугаар заалтад дурдсан татваруудтай адил буюу төстэй байвал энэхүү Хэлэлцээрт мөн хамрагдана. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллага нь

өөрийн орны татварын хуульд орсон аливаа зарчмын өөрчлөлтийн талаар нөгөө талдаа зохих хугацаанд мэдэгдэнэ.

3 дугаар зүйл. Ерөнхий тодорхойлолт

1. Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол:

а/ "Монгол" гэж БНМАУ, газар зүйн утгаараа БНМАУ-ын бүх нутаг дэвсгэрийг хэлнэ;

б/ "Хятад" гэж БНХАУ, газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх нутаг дэвсгэрийг хэлэх бөгөөд мөн хятадын татварын хууль үйлчлэх БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгис, түүнчлэн олон улсын хуулийн дагуу нөөцийг нь БНХАУ олборлох, ашиглах эрх бүхий далайн ёроол, түүний хэвлий, /далайн ёроолоос дээших усны нөөц баялаг/ БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгисээс гадагш орших нутгийг хэлнэ;

в/ "Хэлэлцэн тохирогч Улс", "Хэлэлцэн тохирогч нөгөө Улс" гэж Хэлэлцээрийн заалтын утгаас хамааран Монгол болон Хятадыг хэлнэ;

г/ "Татвар" гэж Хэлэлцээрийн заалтын утгаас хамааран Монголын татвар эсвэл Хятадын татварыг хэлнэ;

д/ "Этгээд" гэж хувь хүн, компани болон бусад этгээдийг хэлнэ;

е/ "Компани" гэж хуулийн эрх бүхий зохион байгуулалттай бүлэг буюу татвар оногдуулах утгаараа түүнтэй адилтгах байгууллагыг хэлнэ.

ж/ "Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж" гэж тухайн энэ улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ. "Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж" гэж тухайн нөгөө улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ;

з/ "Харьяа" гэж Хэлэлцэн тохирогч Улсын харьяат бүх хувь этгээд болон Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу зөвшөөрөгдөн ажиллаж буй хуулийн бүх этгээд, татвар оногдуулах утгаараа түүнтэй адилтгах хуулийн бус этгээдийг хэлнэ;

к/ "Олон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч аль нэгэн Улсад удирдах газар нь байрладаг аж ахуйн нэгжээс хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай замын тээврийн хэрэгслээр хийх аливаа тээврийн үйл ажиллагааг хэлнэ. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь цэгүүдийн хооронд хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна;

л/ "Эрх бүхий байгууллага" гэж Монголын хувьд БНМАУ-ын Сангийн яам буюу түүний эрх бүхий төлөөлөгч, Хятадын хувьд БНХАУ-ын Улсын татварын товчоо буюу түүний эрх бүхий төлөөлөгч

чийг хэлнэ.

2. Энэхүү Хэлэлцээрт тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрээр зохицуулагдаж буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно.

4 дүгээр зүйл. Байнга оршин суугч

1. Энэхүү Хэлэлцээрт "Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад байнга оршин суугч" гэж өөрөө болон удирдах, толгойлох байгууллага нь байнга оршин сууж, байрлаж байгаа, мөн үүнтэй адилтгах бусад шалтгаанаар оршин сууж, байрлаж тэр Улсын хуулийн дагуу тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч хувь этгээдийн статусыг дараах байдлаар тодорхойлно:

а/ байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа /язгуур эрх ашгийн төв/ нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно.

б/ хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий улсыг тодорхойлох аргагүй, эсвэл энэ хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түр орогнох байртай байгаагаар нь тэр улсад байнга оршин суугч гэж тооцно.

в/ хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь түр орогнох байртай, эсвэл алинд нь ч байхгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль улсын харъяат байгаагаар нь тэр улсад байнга оршин суугч гэж тооцно.

г/ хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины харъяат эсвэл алиных нь ч харъяат биш бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу хувь этгээдээс бусад хуулийн этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршдог бол түүний удирдах газар нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

5 дугаар зүйл. Төлөөлөгчийн газар

1. Энэхүү хэлэлцээрт "Төлөөлөгчийн газар" гэж аж ахуйн нэгж

өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг байрлалыг хэлнэ.

2. "Төлөөлөгчийн газар" гэдэгт тухайлбал:

- а/ аж ахуйг удирдан явуулж буй газар;
- б/ салбар байгууллага;
- в/ албан контор;
- г/ үйлдвэр, завод;
- д/ цех, тасаг;
- е/ уурхай, газрын тос, байгалийн хий болон байгалийн бусад ашигт малтмал олборлож буй газар орно.

3. "Төлөөлөгчийн газар" гэдэгт түүнчлэн дараах зүйлийг хамааруулна:

а/ 18 сараас илүү хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт, суурилуулалтын ажил болон эдгээртэй холбогдсон удирдлага, хяналтын үйл ажиллагаа;

б/ 18 сараас илүү хугацаагаар үргэлжлэх тухайн барилга байгууламж, эсвэл түүнтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажиллаж буй ажиллагсдаараа дамжуулан Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн газраас үйлчилгээ үзүүлэх, үүнтэй холбогдсон зөвлөлгөө өгөх ;

4. Энэхүү зүйлийн 1-ээс 3 дугаар заалтад дурдсан "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараах үйл ажиллагааг үл хамааруулна:

а/ аж ахуйн нэгж зөвхөн өөрийн бараа, эд агуурсыг хадгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор аливаа байгууламж ашиглахыг;

б/ аж ахуйн нэгж зөвхөн хадгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор бараа, эд агуурс нөөцлөхийг;

в/ аж ахуйн нэгж өөр бусад аж ахуйн нэгжээр зөвхөн боловсруулалт хийлгэх зорилгоор бараа, эд агуурс нөөцлөхийг;

г/ аж ахуйн нэгжид зориулан бараа, эд агуурс зөвхөн худалдан авах, мэдээлэл цуглуулах зориулалттай үйл ажиллагаагаа явуулдаг байр ашиглахыг;

д/ аж ахуйн нэгжийн бэлтгэх, туслах чанарын аливаа үйл ажиллагаа явуулах зорилгоор байр ашиглахыг;

ё/ энэ заалтын "а" - аас "д" -д заасан үйл ажиллагааг

зөвхөн бэлтгэх болон туслах чанарын ажлын зориулалтаар хослуулан эрхлэх байр ашиглах.

5. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан 6 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж гэрээ/контракт/ байгуулах эрх эдэлдэг бол уг аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газартай гэж үзнэ. Гэхдээ уг этгээдийн үйл ажиллагаа 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан улмаар энэ ажиллагааг явуулж буй байр нь дээрх заалтын дагуу төлөөлөгчийн газар болж чадахгүй тохиолдолд уг аж ахуйн газрыг төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

6. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад брокер, ерөнхий комиссын төлөөлөгч, бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа нь түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэх үндэс болохгүй бөгөөд тэдгээр этгээд нь өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байх нь үүний нөхцөл болно. Гэхдээ тийм төлөөлөгчийн үйл ажиллагаа нь бүхэлдээ буюу дийлэнхдээ уг аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс хийгдэж байгаа бол түүнийг бие даасан эрх бүхий төлөөлөгч гэж энэхүү заалтанд хамааруулахгүй.

7. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаагаа /төлөөлөгчийн газраар дамжуулан буюу бусад аргаар/ явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтанд байдаг нь эдгээр компанийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

6 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгөнөөс орох орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг үл хөдлөх эд хөрөнгөнөөс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч орлого олбол уг орлогоос энэхүү хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улс татвар авч болно.

2. "Үл хөдлөх эд хөрөнгө" гэдгийг тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд заасны дагуу тодорхойлно. Аль ч тохиолдолд уг нэр томъёонд үл хөдлөх эд хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйд ашиглагдаж буй мал, амьтан, тоног төхөөрөмж; газар оролцсон өмчийн талаарх хуулийн заалт хэрэглэгдэх эрх; бусдын үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшин ашиглах эрх; уурхай, ашигт малтмалын орд, рашаан ус болон байгалийн бусад баялгийн хөдөлгөөнт болон тогтмол төлбөрийн эрхийг багтаана. Харин хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай замын тээврийн хэрэгсэл үл хөдлөх эд хөрөнгөд үл тооцогдоно.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх эд хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсвэл бусад аль ч хэлбэрээр

ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээнд ашигласан үл хөдлөх эд хөрөнгөнөөс олсон орлогод хамаарна.

7 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар оногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан үйл ажиллагаа эрхэлбэл уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн төлөөлөгчийн газарт хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар оногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагаа, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрт тооцно.

3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулахад тус төлөөлөгчийн газраас өөрийн байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад улсад зарцуулсан аж ахуйн болон захиргааны зардлыг хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсад аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт орлогыг хуваарилдаг аргаар байнган төлөөлөгчийн газрын орлогыг тодорхойлж хэвшсэн бол Хэлэлцэн тохирогч Улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход энэхүү зүйлийн 2 дугаар заалт саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэ зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

5. Аж ахуйн нэгж нь төлөөлөгчийн газраар дамжуулан бараа, эд агуурсыг зөвхөн худалдан авдаг бол үүнийг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн 1-ээс 5 дугаар заалтад нийцүүлэн төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлохдоо, өөрчлөх баттай үндэслэлгүй бол тогтсон нэг арга хэрэглэнэ.

7. Хэрэв аж ахуйн үйл ажиллагааны ашиг нь энэхүү Хэлэлцээрийн бусад зүйлд тусгайлан тодорхойлсон төрлийн орлогыг агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8 дугаар зүйл. Ус, агаар, хуурай замын тээвэр

1. Олон улсын шугамд хөлөг онгоц, нисэх онгоц болон хуурай замын тээврийн хэрэгслээр тээвэр хийж олох ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн удирдах, толгойлох байгууллага нь оршдог Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулна.

2. Хэрэв усан замын тээврийн байгууллагын удирдах газар нь хөлөг онгоцон дээрээ байрладаг бол энэхүү хөлөг онгоцны харьяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад, хэрэв харьяалах боомт үгүй бол уг хөлөг онгоцны эзэмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад түүнийг байрладаг гэж үзнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь пул, хамтын ажиллагаа, олон улсын тээврийн зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

9 дүгээр зүйл. Хоршсон аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а/ Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд болон шууд бусаар оролцдог бол;

б/ тодорхой этгээдүүд Хэлэлцэн тохирогч Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт буюу хөрөнгөнд шууд юм уу шууд бусаар оролцож байгаа аль ч тохиолдолд тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөлд нь биеэ даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцөлөөс ялгаатай байвал тухайн аж ахуйн нэгжид оногдох ёстой аливаа ашиг дээрх ялгаатай нөхцөлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар оногдуулна.

2. Хоёр аж ахуйн нэгжийн хоорондын харилцаа нь бие даасан аж ахуйн нэгжийн хоорондын харилцааны нөхцөлтэй нийцэж байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө улсын аж ахуйн нэгжээс өөрийн Улсдаа татвар авах ёстой ашгийг Хэлэлцэн тохирогч Улс өөрийн аж ахуйн нэгжийн ашигт оруулан татвар ногдуулсан байвал Хэлэлцэн тохирогч нөгөө Улс энэхүү ашгаас авах татварын хэмжээнд холбогдох зохицуулалт хийнэ. Ийм зохицуулалтыг энэхүү Хэлэлцээрийн бусад заалт, Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагуудын саналыг үндэслэн хийнэ. Шаардлагатай бол харилцан зөвлөлдөж болно.

10 дугаар зүйл. Дивиденд

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршигч этгээдэд төлж буй дивидендэд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар оногдуулж болно.

2. Гэхдээ дивиденд төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улс тухайн дивидендэд өөрийн хууль тогтоомжийн дагуу татвар оногдуулж болох боловч дивиденд авагч этгээд нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол оногдуулах татварын хэмжээ нь дивидендийн нийт дүнгийн 5 хувиас хэтрэх ёсгүй.

Энэхүү заалт нь тухайн компанийн дивиденд агуулсан ашигт оногдуулах татварт үл хамаарна.

3. Энэхүү зүйлд тусгагдсан "Дивиденд" гэсэн нэр томъёо нь хувьцааны ноогдол ашиг, ашигт өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр оролцох эрхээс үүсэх орлого болон түүнтэй адилтгах бусад орлого, түүнчлэн хуваарилалт хийж буй хуулийн этгээд байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсын хууль зүйн дагуу хувьцааны орлоготой адилтган татвар оногдуулдаг бусад орлогыг илэрхийлнэ.

4. Хэрэв дивидендийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог бөгөөд дивиденд төлөгч компани байрладаг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг төвлөсөн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг ба дивидендийн эрх хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу төвлөсөн газарт шууд хамааралтай бол 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал Хэлэлцэн тохирогч нөгөө Улс уг компаний төлж буй дивидендэд татвар оногдуулахгүй байж болно. Гэхдээ уг компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж байгаа дивиденд буюу дивиденд авах эрх нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар ба төвлөсөн газартай шууд хамааралтай бол татвар оногдуулж болно.

Харин компаний хуваарилагдаагүй ашигт энэхүү хуваарилагдаагүй ашиг, төлөгдсөн дивиденд нь бүхэлдээ буюу хэсэгчлэн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бий болсон ашиг, орлогоос бүрэлдэж байлаа ч гэсэн татвар оногдуулахгүй байж болно.

11 дүгээр зүйл. Хүү

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар оногдуулж болно.

2. Гэхдээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар оногдуулж болох боловч, хэрэв уг хүүг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол оногдуулах татварын хэмжээ нийт хүүний 10 хувиас хэтэрч болохгүй.

3. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын

Засгийн газар, түүний орон нутгийн эрх барих байгууллага, Төв банк болон энэхүү Засгийн газарт бүрэн харьяалагдах аливаа санхүүгийн байгууллага буюу эдгээрээс баталгаа олгосон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч бусад этгээдэд төлсөн хүүд Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулахгүй.

4. Энэхүү зүйлд тусгагдаж буй "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөнд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого, ялангуяа улсын зээллэгээ, бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого орно. Харин төлбөр тооцоо хожимдуулсны торгууль нь энэхүү зүйлд дурдсан хүү гэж тооцогдохгүй.

5. Хэрэв хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болн байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраас хувийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1, 2, 3 дугаар заалтыг мөрдлөг болгохгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Хүү төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар, орон нутгийн эрх барих байгууллага буюу уг Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бол, хүүг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан, хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газарт бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад хүүг бий болсон гэж үзнэ.

7. Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчийн хооронд, мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал, энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэ Хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан татвар оногдуулж болно.

12 дугаар зүйл. Шан харамж, эрхийн шимтгэл

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж буй шан харамж, эрхийн шимтгэлд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулж

болно.

2. Гэхдээ хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа шан харамж, эрхийн шимтгэлд тухайн улсын хуулийн дагуу татвар оногдуулж болох боловч уг шан харамж, эрхийн шимтгэлийг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ийнхүү оногдуулж буй татвар нь шан харамж, эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 10 хувиас хэтэрч үл болно.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй "шан харамж, эрхийн шимтгэл" гэсэн ойлголтод, уран зохиолын хэвлэн нийтлэх эрх, урлаг уран сайхан болон шинжлэх ухааны бүтээл, түүний дотор уран сайхны кино, бусад кино, радио болон телевизийн нэвтрүүлэгт зориулсан бичлэг, патент, ноу-хау, барааны тэмдэг болон дизайн, үүний зэрэгцээ загвар, зураг төсөл болон нууц томъёолол буюу процессийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, эсвэл үйлдвэрлэл, худалдаа буюу шинжлэх ухааны багаж хэрэгсэл, эсвэл үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөрийг хамааруулна.

4. Хэрэв шан харамж, эрхийн шимтгэл жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог төвлөсөн газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг, түүнчлэн шан харамж, эрхийн шимтгэл авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзана. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Шан харамж, эрхийн шимтгэл төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар, орон нутгийн эрх барих байгууллага буюу уг Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бол, уг шан харамж, эрхийн шимтгэл Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан шан харамж, эрхийн шимтгэл төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газраар дамжуулан шан харамж, эрхийн шимтгэл төлөх үүрэг хүлээж шан харамж, эрхийн шимтгэл нь тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газарт бий болсон бол төлөөлөгчийн газар эсвэл төвлөсөн газрын оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад шан харамж, эрхийн шимтгэл бий болсон гэж үзнэ.

6. Шан харамж, эрхийн шимтгэл төлөх болон авах эрхийг жинхэнэ эзэмшигчийн хооронд, мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөмжнийг этгээдийн хоорондын онцлог харилцааны улмаас ашиглаж хэрэглэх, эрх авах ба мэдээллийн хувьд төлөгдсөн шан харамж, эрхийн шимтгэлийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиол-

долд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар оногдуулна.

13 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд хамаарах үл хөдлөх эд хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх эд хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харъяалагдах хөдлөх эд хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого, мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар /дангаар нь эсвэл бүх аж ахуйн газрын хамт/ буюу ийм товлосон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоц болон хуурай замын тээврийн хэрэгсэл буюу эдгээр тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамрагдах хөдлөх эд хөрөнгө худалдаж борлуулснаас олсон орлогод ийм тээврийн хэрэгслийг ашиглаж буй тухайн аж ахуйн нэгжийн удирдах газар нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулж болно.

4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь шууд ба шууд бус байдлаар гол төлөв Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг үл хөдлөх эд хөрөнгөнөөс бүрддэг бол, хувь нийлүүлсэн хөрөнгөний хувьцааг худалдаж борлуулснаас олох орлогод Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулж болно.

5. Энэхүү зүйлийн 4 дүгээр заалтад дурдсанаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч нь тухайн компанийн үл хөдлөх хөрөнгийн 25-аас багагүй хувийг эзэмшдэг бол, энэхүү эзэмшиж буй хөрөнгийн хувьцааг худалдаж борлуулснаас олох орлогод Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулж болно.

6. Энэхүү зүйлийн 1-ээс 6 дугаар заалтад зааснаас бусад аливаа хөрөнгийг худалдан борлуулснаас олох орлогод зөвхөн уг хөрөнгийг худалдсан этгээдийн байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулж болно.

14 дүгээр зүйл. Бие даасан хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчаас мэргэжлийн

үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа өөр үйл ажиллагаа эрхлэн олсон орлогоос зөвхөн энэхүү Хэлэлцэн тохирогч Улс татвар авч болно. Гэхдээ байнга оршин суугчийн орлогоос дараах нөхцөлд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулж болно:

а/ хэрэв байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагааг явуулахад байнга ашиглаж болох төвлөсөн газартай бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад түүний орлогын зөвхөн төвлөсөн газарт хамаарах хэсэгт татвар оногдуулж болно;

б/хэрэв байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад нийт байсан хугацаа нь тухайн жилийн хуанлийн 183 өдрөөс давсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад энэ хугацаанд явуулсан үйл ажиллагаанд оногдох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэдэг нь шинжлэх ухаан, уран зохиол, соёл урлаг, боловсрол болон багшлах бие даасан үйл ажиллагаа, түүнчлэн эмч, өмгөөлөгч, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.

15 дугаар зүйл. Бие даасан бус хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлэгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс, болон түүнтэй адилтгах орлогод 16, 18, 19, 20 ба 21 дүгээр зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар оногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлгээнээс олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулна.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж буй ажил үйлчилгээнээс олсон орлогод Хэлэлцэн тохирогч Улс дор дурдсан нөхцөлд татвар оногдуулна:

а/ орлого авагч нь тухайн хуанлийн жилд нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол;

б/ орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй этгээд өөрөө, эсвэл энэ этгээдийн нэрийн өмнөөс төлсөн бол;

в/ орлогыг уг этгээдийг хөлслөгчийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар буюу төвлөсөн газар нь төлөөгүй бол;

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжээс олон улсын шугамд тээвэр хийж буй хөлөг онгоц, нисэх онгоц, хуурай замын тээврийн хэрэгсэл дотор гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн удирдах газар нь байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулна.

16 дугаар зүйл. Захирлуудын шагнал, урамшил

Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь компанийн захирлуудын зөвлөлийн гишүүний хувьд авсан

цалин болон түүнтэй адилтгах бусад төрлийн шагнал урамшуулал зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулна .

17 дугаар зүйл. Урлагийн ажилтнууд ба тамирчид

1. Энэхүү Хэлэлцээрийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугаа театр, киноны жүжигчин, радио буюу телевизийн урлагийн ажилтан, хөгжимчин буюу тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулж болно

2. Энэхүү Хэлэлцээрийн 7 ,14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан урлагийн ажилтан, тамирчны олсон орлого өөрт нь биш оногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулж болно.

3. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсад оршин суугч жүжигчин буюу тамирчнаас Хэлэлцэн тохирогч Улсуудын Засгийн газрын хооронд байгуулсан соёлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулахгүй.

18 дугаар зүйл. Тэтгэвэр

1. Энэхүү хэлэлцээрийн 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Улсад оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажлын тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөрт зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу орон нутгийн эрх барих байгууллагын нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад төлбөрт Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулна

19 дүгээр зүйл. Засгийн газрын алба

1. а/ Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу орон нутгийн эрх барих байгууллагаас тухайн байгууллагад алба хашиж байсны хувьд болон Засгийн газрын чанартай үүргээс нь чөлөөлөгдсөний хувьд олгох төлбөрт /тэтгэврээс бусад / тухайн Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулна.

б/ гэхдээ уг хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад алба хашиж байгаа ба тэнд байнга оршин суугч бол дараах тохиолдолд түүнд олгох төлбөрт зөвхөн уг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулна. Үүнд :

1. Тэр улсын харьат ;
2. Гагцхүү алба хаших үүднээс тэр улсын байнга

оршин суугч болоогүй

2. а/ Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу орон нутгийн эрх барих байгууллагад алба хашиж байсны хувьд тэр Улсын Засгийн газар буюу орон нутгийн эрх барих байгууллагын хандив буюу тэтгэврийн сангаас олгосон аливаа төлбөрт зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулна.

б/ гэхдээ уг хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч бөгөөд тэр улсын харъяат нь бол дээр дурдсан тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар оногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч Улсын Засгийн газар буюу орон нутгийн эрх барих байгууллагаас аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хашсаны хувьд олгосон төлбөр, тэтгэвэр нь энэхүү хэлэлцээрийн 15, 16, 17 ба 18 дугаар зүйлд хамаарна.

20 дугаар зүйл. Багш, эрдэм шинжилгээний ажилтан нар

Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан буюу одоо хэвээр байгаа, Хэлэлцэн тохирогч Улсад Улсын засгийн газрын зөвшөөрснөөр их, дээд, дунд сургуульд эсвэл боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнд зөвхөн хичээл заах, лекц унших буюу шинжилгээ судалгааны ажил хийхээр ирсэн хувь этгээдийн Хэлэлцэн тохирогч Улсад анх ирсэн өдрөөс эхлэн 3 жил хүртэл хугацаанд хичээл заах, лекц унших, судалгаа шинжилгээний ажил хийсний хөлсөнд авсан шагнал урамшилд Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулахгүй.

21 дүгээр зүйл. Оюутан, сурагч, дадлага хийгчид

Хэлэлцэн тохирогч Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан буюу одоо хэвээр байгаа, бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсад гагцхүү суралцах, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, сурагч, дадлага хийгчийн өөрийн хангамж болон сурлага, дадлагадаа зориулан авсан болон олсон дараах орлогод Хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулахгүй:

а/ өөрийгөө тэжээх, суралцах, судалгаа, дадлага, эрдэм шинжилгээний ажил хийхэд зориулан Хэлэлцэн тохирогч Улсын гадна эх үүсвэрээс авч байгаа тэтгэлэг;

б/ Засгийн газар, шинжлэх ухаан, соёл боловсрол болон татвараас чөлөөлөгдөх бусад байгууллагаас олгох тэтгэлэг, шагнал, урамшил;

в/ Хэлэлцэн тохирогч Улсад гүйцэтгэсэн хувийн үйлчилгээний орлого.

22 дугаар зүйл. Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн олж буй энэхүү хэлэлцээрийн өмнөх зүйлүүдэд хөндөгдөөгүй аливаа орлогод зөвхөн хэлэлцэн тохирогч Улсад татвар оногдуулна.

2. Хэрэв орлого олгогч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төвлөсөн газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба эд хөрөнгө нь энэ төлөөлөгчийн газар буюу төвлөсөн газартай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалт үл хамаарна. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

23 дугаар зүйл. Давхар татвараас чөлөөлөх аргууд

1. Хятад улсад давхар татвараас дараах байдлаар чөлөөлнө.
Үүнд:

а/ Хятадын байнга оршин суугч Монгол улсад орлого олж байвал энэхүү Хэлэлцээрийн дагуу уг орлогоос Монгол улсад төлбөл зохих татварын дүнг тухайн оршин суугчийн нийт орлогод оногдуулах Хятадын татварын дүнгээс хасч тооцно. Гэхдээ уг татварын хасах дүн нь Хятадын татварын хувь хэмжээнээс хэтрэхгүй байна.

б\ Монгол улсаас олж буй орлого нь Монгол улсын байнга оршин суугч компаниас Хятадын байнга оршин суугч компанид төлж буй дивиденд бөгөөд уг компани нь дивиденд төлж буй компаний хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа тохиолдолд энэхүү зүйлийн дээрх заалтад дурдсан татварын хасах дүнг тогтоохдоо дивиденд төлж буй компаний орлогын хэмжээнээс Монгол улсад төлбөл зохих татварыг хасч тооцно.

2. Монгол улсын хувьд давхар татвараас дараах байдлаар чөлөөлнө.
Үүнд:

а/ Монголын байнга оршин суугч Хятад улсад орлого олж байвал энэхүү Хэлэлцээрийн дагуу уг орлогоос Хятад улсад төлбөл зохих татварын дүнг тухайн оршин суугчийн нийт орлогод оногдуулах Монголын дүнгээс хасч тооцно. Гэхдээ уг татварын хасах дүн нь Монголын татварын хууль, дүрмийн дагуу тухайн орлогод оногдвол зохих Монголын татварын хувь хэмжээнээс хэтрэхгүй байна.

б\ Хятад улсаас олж буй орлого нь Хятад улсын байнга оршин суугч компаниас Монголын байнга оршин суугч компанид төлж буй дивиденд бөгөөд уг компани нь дивиденд төлж буй компанийн хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа тохиолдолд энэхүү зүйлийн дээрх заалтад дурдсан татварын хасах дүнг тогтоохдоо дивиденд төлж буй компаний орлогын хэмжээнээс Хятад улсад төлбөл зохих татварыг хасч тооцно.

24 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах явдал
гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч Улсын харьяат Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаардлагын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харьяатаас татварын адилгүй буюу илүү хүндрэлтэй нөхцөлд оруулахгүй. Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн үл харгалзан уг заалт нь Хэлэлцэн тохирогч Улсуудын аль нэгэнд нь, эсвэл алинд нь ч оршин суудаггүй этгээдэд мөн адил хамаарна.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг төлөөлөгчийн газраас татвар төлөх нөхцөлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад түүнтэй адилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцөлөөс доор байлгаж болохгүй. Дээрх заалт нь Хэлэлцэн тохирогч Улс нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчдыг иргэний эрх, гэр бүлийн хариуцлагын хувьд өөрийн байнга оршин суугчдын адил татвараас чөлөөлөх, хөнгөлөх, багасгах эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэгдэхгүй.

3. Энэхүү хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт, 11 дүгээр зүйлийн 7 дугаар заалт, 12 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн татвар оногдох ашгийг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлж буй хүү, шан харамж, эрхийн шимтгэл болон бусад төлбөрийг хасна. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдэд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчдаас төлж байгаа ийм төлбөрийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хасч байгаатай адил нөхцөлтэй байна.

4. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд бусаар бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн өмчлөх буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч Улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцөлөөс адилгүй буюу илүү хүндрэлтэй байдалд оруулахгүй.

25 дугаар зүйл. Харилцан тохирох журам

1. Хэрэв аливаа этгээд Харилцан тохирогч аль нэг Улс энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар түүнд оногдуулсан буюу оногдуулах болно гэж үзвэл тухайн улсын хууль тогтоомжийн нэмэлт заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улс буюу /хэрэв түүнд 24 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтыг хэрэглэсэн бол/ харьяат Улсынхаа эрх бүхий байгууллагад гомдлоо гаргаж болно. Гомдлыг энэхүү хэлэлцээрт заагдаагүй татвар оногдуулж байна гэж анх мэдсэнээс хойш 3 жилийн дотор гаргана.

2. Гомдлыг нотлож хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол

Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллага энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар оногдуулахгүй байх зорилгоор харилцан тохирох бүх арга хэмжээ авна. Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч аль нэг Улсын хууль тогтоомжийн цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгслэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохирох журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Хэлэлцээрт заагдаагүй орлогыг давхар татвараас чөлөөлөх асуудлыг тэд хамтран шийдвэрлэж болно.

4. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү зүйлийн 2 ба 3 дугаар заалтын талаар тохиролцоонд хүрэх зорилгоор еер хоорондоо шууд харилцаж болно. Хэрэв шаардлагатай бол тохиролцоонд хүрэхийн тулд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчид санал солилцох зорилгоор биечлэн уулзаж болно.

26 дугаар зүйл. Харилцан мэдээлэл солилцох

1. Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын талаарх хоёр Улсын хууль тогтоомж болон уг хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэхэд шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна.

Хоёр улсын татварын талаарх хууль тогтоомж, татвар оногдуулалт нь энэхүү хэлэлцээр, түүний дотор татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд харшлах ёсгүй. Мэдээлэл харилцан солилцох нь 1 дүгээр зүйлээр үл хязгаарлагдана. Хэлэлцэн тохирогч Улс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсаас хүлээн авсан мэдээллийг нууцалж, зөвхөн энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын асуудалтай холбоо бүхий этгээдүүд, эрх барих байгууллагуудад /шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан/ мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд, эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын хэмжээг тодорхойлох, хураан дайчлах, албадах, ял шийтгэл оноох, даван заалдахыг тогтоох зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийдвэрт тусгаж болно.

2. Дээрх заалт нь ямар ч тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсад дараах үүргийг хүлээлгэх ёсгүй:

а/ Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ хэрэгжүүлэх;

б/ Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль тогтоомж болон захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээллээр хангах;

в/ Хэлэлцэн тохирогч Улсуудын худалдаа, бизнес, аж үйлд-

вэр, мэргэжлийн нууц алдагдуулах мэдээ болон нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах;

27 дугаар зүйл. Дипломат ба консулын төлөөлөгчдийн газрын ажилтнууд

Энэхүү Хэлэлцээр нь олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээ болон тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу дипломат ба консулын төлөөлөгчдийн эдлэх санхүүгийн эрх дархыг үл хөндөнө.

28 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох тухай

Энэхүү Хэлэлцээр нь хоёр улс уг Хэлэлцээрийг дотооддоо мөрдөж буй холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр болгон баталж дипломат ноот солилцсон өдрөөс хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү Хэлэлцээр нь уг Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон татварын жил болон дараа жилийн 1 дүгээр сарын эхний өдрөөс эхлэх хуанлийн жилүүдэд олох орлогод хамаарна.

29 дүгээр зүйл. Дуусгавар болох хугацаа

Энэхүү Хэлэлцээр нь хугацаагүй мөрдөгдөх боловч Хэлэлцэн тохирогч аль нэгэн Улс уг Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа түүнийг цуцлах тухайгаа хуанлийн жилийн 6 дугаар сарын 30-ны өдөр буюу түүнээс өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад дипломат шугамаар бичгээр мэдэгдэж болно.

Ингэсэн тохиолдолд уг Хэлэлцээр нь мэдэгдэл өгсөн өдрөөс хойш эхлэх татварын жилүүд эсвэл 1 дүгээр сарын эхний өдрөөс хойш олсон орлогын хувьд хүчингүй болсонд тооцно.

Энэхүү Хэлэлцээрийг 1991 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, хятад, англи гурван хэл дээр үйлдсэн бөгөөд гурван эх хувь нь адил хүчинтэй. Гарч болох маргаантай асуудлыг шийдвэрлэхэд Англи эх хувийг баримтлана.

БҮГД НАИРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАИРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

П Р О Т О К О Л


Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээрт /энд болон цаашид "Хэлэлцээр" гэнэ/ хоёр тал гарын үсэг зурахдаа Хэлэлцээрийн салшгүй хэсэг болох дараах зүйлийн талаар тохиролцов.

Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд холбогдуулан


Энэхүү хэлэлцээрийн аль ч зүйл нь хоёр засгийн газрын хооронд 1989 оны 4 дүгээр сарын 8-нд гарын үсэг зурсан Иргэний агаарын тээврийн Хэлэлцээр болон 1991 оны 6 дугаар сарын 24-нд Бээжин хотноо гарын үсэг зурсан Авто тээврийн Хэлэлцээрийн татварын тухай заалтуудыг мөрдөхөд нөлөөлөхгүй.

Энэхүү Протоколыг 1991 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, хятад, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд гурван эх хувь нь адил хүчинтэй. Протоколыг тайлбарлах талаар маргаан гарвал англи эхийг баримтална.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



蒙古人民共和国政府和中华人民共和国政府关于对所得避免双重征税和防止偷漏税的协定

蒙古人民共和国政府和中华人民共和国政府，愿意缔结关于对所得避免双重征税和防止偷漏税的协定，达成协议如下：

第一条 人的范围

本协定适用于缔约国一方或者同时为双方居民的人。

第二条 税种范围

一、本协定适用于由缔约国一方或其地方当局对所得征收的所有税收，不论其征收方式如何。

二、对全部所得或某项所得征收的税收，包括对来自转让动产或不动产的收益征收的税收以及对资本增值征收的税收，应视为对所得征收的税收。

三、本协定适用的现行税种是：

(一) 在蒙古人民共和国：

- 1、个人所得税；
- 2、外商投资企业所得税；
- 3、外国企业所得税；
- 4、地方所得税。

(以下简称“蒙古税收”)

(二) 在中华人民共和国：

- 1、个人所得税；
- 2、外商投资企业和外国企业所得税；
- 3、地方所得税。

(以下简称“中国税收”)

四、本协定也适用于本协定签订之日后征收的属于增加或者代替第三款所列现行税种的相同或者实质相似的税收。缔约国双方主管当局应将各自税法所作的实质变动，在其变动后的适当时间内通知对方。

第三条 一般定义

一、在本协定中，除上下文另有解释的以外：

(一) “蒙古”一语是指蒙古人民共和国；用于地理

概念时，是指蒙古人民共和国领土；

(二) “中国”一语是指中华人民共和国；用于地理概念时，是指实施有关中国税收法律的所有中华人民共和国领土，包括领海，以及根据国际法，中华人民共和国拥有勘探和开发海底和底土资源以及海底以上水域资源的主权权利的领海以外的区域；

(三) “缔约国一方”和“缔约国另一方”的用语，按照上下文，是指蒙古或者中国；

(四) “税收”一语按照上下文，是指蒙古税收或者中国税收；

(五) “人”一语包括个人、公司和其他团体；

(六) “公司”一语是指法人团体或者在税收上视同法人团体的实体；

(七) “缔约国一方企业”和“缔约国另一方企业”的用语，分别指缔约国一方居民经营的企业和缔约国另一方居民经营的企业；

(八) “国民”一语是指所有具有缔约国一方国籍的个人和所有按照该缔约国法律建立或者组织的法人，以及所有在税收上视同按照该缔约国法律建立或者组织成法人

的所有非法人团体；

(九) “国际运输”一语是指在缔约国一方设有总机构的企业以船舶、飞机或陆运工具经营的运输，不包括仅在缔约国另一方各地之间以船舶、飞机或陆运工具经营的运输；

(十) “主管当局”一语，在蒙古方面是指财政部或其授权的代表；在中国方面是指国家税务局或其授权的代表。

二、缔约国一方在实施本协定时，对于未经本协定明确定义的用语，除上下文另有解释的以外，应当具有该缔约国适用于本协定的税种的法律所规定的含义。

第四条 居 民

一、在本协定中，“缔约国一方居民”一语是指按照该缔约国法律，由于住所、居所、总机构所在地，或者其它类似的标准，在该缔约国负有纳税义务的人。

二、由于第一款的规定，同时为缔约国双方居民的个人，其身份应按以下规则确定：

(一) 应认为是其有永久性住所所在缔约国的居民；

如果在缔约国双方同时有永久性住所，应认为是与其个人和经济关系更密切（重要利益中心）所在缔约国的居民；

（二）如果其重要利益中心所在国无法确定，或者在缔约国任何一方都没有永久性住所，应认为是其有习惯性居处所在国的居民；

（三）如果其在缔约国双方都有，或者都没有习惯性居处，应认为是其国民所属缔约国的居民；

（四）如果其同时是缔约国双方的国民，或者不是缔约国任何一方的国民，缔约国双方主管当局应通过协商解决。

三、由于第一款的规定，除个人以外，同时为缔约国双方居民的人，应认为是其总机构所在缔约国的居民。

第五条 常设机构

一、在本协定中，“常设机构”一语是指企业进行全部或部分营业的固定营业场所。

二、“常设机构”一语特别包括：

（一）管理场所；

（二）分支机构；

- (三) 办事处；
- (四) 工厂；
- (五) 作业场所；
- (六) 矿场、油井或气井、采石场或者其它开采自然资源的场所。

三、“常设机构”一语还包括：

(一) 建筑工地，建筑、装配或安装工程，或者与其有关的监督管理活动，但仅以该工地、工程或活动连续十八个月以上的为限；

(二) 缔约国一方企业通过雇员或者雇用的其他人员，在缔约国另一方为同一个项目或相关联的项目提供的劳务，包括咨询劳务，仅以连续或累计十八个月以上的为限。

四、虽有第一款至第三款的规定，“常设机构”一语应认为不包括：

(一) 专为储存、陈列或者交付本企业的货物或者商品的目的而使用的设施；

(二) 专为储存、陈列或者交付的目的而保存本企业货物或者商品的库存；

(三) 专为另一企业加工的目的而保存本企业货物或者商品的库存;

(四) 专为本企业采购货物或者商品, 或者搜集情报的目的所设的固定营业场所;

(五) 专为本企业进行其它准备性或辅助性活动的目的所设的固定营业场所;

(六) 专为本款第(一)项至第(五)项活动的结合所设的固定营业场所, 如果由于这种结合使该固定营业场所的全部活动属于准备性质或辅助性质。

五、虽有第一款和第二款的规定, 当一个人(除适用第六款规定的独立代理人以外)在缔约国一方代表缔约国另一方的企业进行活动, 有权并经常行使这种权力以该企业的名义签订合同, 这个人为该企业进行的任何活动, 应认为该企业在该缔约国一方设有常设机构。除非这个人通过固定营业场所进行的活动限于第四款的规定, 按照该款规定, 不应认为该固定营业场所是常设机构。

六、缔约国一方企业仅通过按常规经营本身业务的经纪人、一般佣金代理人或者任何其他独立代理人在缔约国另一方进行营业, 不应认为在该缔约国另一方设有常设机

构。但如果这个代理人的活动全部或几乎全部代表该企业，不应认为是本款所指的独立代理人。

七、缔约国一方居民公司，控制或被控制于缔约国另一方居民公司或者在该缔约国另一方进行营业的公司（不论是否通过常设机构），此项事实不能据以使任何一方公司构成另一方公司的常设机构。

第六条 不动产所得

一、缔约国一方居民从位于缔约国另一方的不动产取得的所得，可以在该缔约国另一方征税。

二、“不动产”一语应当具有财产所在地的缔约国的法律所规定的含义。该用语在任何情况下应包括附属于不动产的财产，农业和林业所使用的牲畜和设备，有关地产的一般法律规定所适用的权利，不动产的用益权以及由于开采或有权开采矿藏、水源和其它自然资源取得的不固定或固定收入的权利。船舶、飞机和陆运工具不应视为不动产。

三、第一款的规定应适用于从直接使用、出租或者任何其它形式使用不动产取得的所得。

四、第一款和第三款的规定也适用于企业的不动产所得和用于进行独立个人劳务的不动产所得。

第七条 营业利润

一、缔约国一方企业的利润应仅在该缔约国征税，但该企业通过设在缔约国另一方的常设机构在该缔约国另一方进行营业的除外。如果该企业通过设在该缔约国另一方的常设机构在该缔约国另一方进行营业，其利润可以在该缔约国另一方征税，但应仅以属于该常设机构的利润为限。

二、除适用第三款的规定以外，缔约国一方企业通过设在缔约国另一方的常设机构在该缔约国另一方进行营业，应将该常设机构视同在相同或类似情况下从事相同或类似活动的独立分设企业，并同该常设机构所隶属的企业完全独立处理，该常设机构可能得到的利润在缔约国各方应归属于该常设机构。

三、在确定常设机构的利润时，应当允许扣除其进行营业发生的各项费用，包括行政和一般管理费用，不论其发生于该常设机构所在国或者其它任何地方。

四、如果缔约国一方习惯于以企业总利润按一定比例分配给所属各单位的方法来确定常设机构的利润，则第二款规定并不妨碍该缔约国按这种习惯分配方法确定其应纳税的利润。但是，采用的分配方法所得到的结果，应与本条所规定的原则一致。

五、不应仅由于常设机构为企业采购货物或商品，将利润归属于该常设机构。

六、在第一款至第五款中，除有适当的和充分的理由需要变动外，每年应采用相同的方法确定属于常设机构的利润。

七、利润中如果包括有本协定其它各条单独规定的所得项目时，本条规定不应影响其它各条的规定。

第八条 海运、空运和陆运

一、以船舶、飞机或陆运工具经营国际运输业务所取得的利润，应仅在企业总机构所在缔约国征税。

二、船运企业的总机构设在船舶上的，应以船舶母港所在缔约国为所在国；没有母港的，以船舶经营者为其居民的缔约国为所在国。

三、第一款规定也适用于参加合伙经营、联合经营或者参加国际经营机构取得的利润。

第九条 联属企业

一、当：

(一) 缔约国一方企业直接或者间接参与缔约国另一方企业的管理、控制或资本，或者

(二) 同一人直接或者间接参与缔约国一方企业和缔约国另一方企业的管理、控制或资本，

在上述任何一种情况下，两个企业之间的商业或财务关系不同于独立企业之间的关系，因此，本应由其中一个企业取得，但由于这些情况而没有取得的利润，可以计入该企业的利润，并据以征税。

二、缔约国一方将缔约国另一方已征税的企业利润，而这部分利润本应由该缔约国一方企业取得的，包括在该缔约国一方企业的利润内，并且加以征税时，如果这两个企业之间的关系是独立企业之间的关系，该缔约国另一方应对这部分利润所征收的税额加以调整。在确定上述调整时，应对本协定其它规定予以注意，如有必要，缔约国双

方主管当局应相互协商。

第十条 股 息

一、缔约国一方居民公司支付给缔约国另一方居民的股息，可以在该缔约国另一方征税。

二、然而，这些股息也可以在支付股息的公司是其居民的缔约国，按照该缔约国法律征税。但是，如果收款人是股息受益所有人，则所征税款不应超过股息总额的百分之五。

本款规定，不应影响对该公司支付股息前的利润所征收的公司利润税。

三、本条“股息”一语是指从股份或者非债权关系分享利润的权利取得的所得，以及按照分配利润的公司是其居民的缔约国法律，视同股份所得同样征税的其它公司权利取得的所得。

四、如果股息受益所有人是缔约国一方居民，在支付股息的公司是其居民的缔约国另一方，通过设在该缔约国另一方的常设机构进行营业或者通过设在该缔约国另一方的固定基地从事独立个人劳务，据以支付股息的股份与该

常设机构或固定基地有实际联系的，不适用第一款和第二款的规定。在这种情况下，应视具体情况适用第七条或第十四条的规定。

五、缔约国一方居民公司从缔约国另一方取得利润或所得，该缔约国另一方不得对该公司支付的股息征收任何税收。但支付给该缔约国另一方居民的股息或者据以支付股息的股份与设在缔约国另一方的常设机构或固定基地有实际联系的除外。对于该公司的未分配的利润，即使支付的股息或未分配的利润全部或部分发生于该缔约国另一方的利润或所得，该缔约国另一方也不得征收任何税收。

第十一条 利 息

一、发生于缔约国一方而支付给缔约国另一方居民的利息，可以在该缔约国另一方征税。

二、然而，这些利息也可以在该利息发生的缔约国，按照该缔约国的法律征税。但是，如果收款人是利息受益所有人，则所征税款不应超过利息总额的百分之十。

三、虽有第二款的规定，发生于缔约国一方而为缔约国另一方政府、地方当局及其中央银行或者完全为其政府

所有的金融机构取得的利息；或者为该缔约国另一方居民取得的利息，其债权是由该缔约国另一方政府、地方当局及其中央银行或者完全为其政府所有的金融机构间接提供资金的，应在该缔约国一方免税。

四、本条“利息”一语是指从各种债权取得的所得，不论其有无抵押担保或者是否有权分享债务人的利润；特别是从公债、债券或者信用债券取得的所得，包括其溢价和奖金。由于延期支付的罚款，不应视为本条所规定的利息。

五、如果利息受益所有人是缔约国一方居民，在利息发生的缔约国另一方，通过设在该缔约国另一方的常设机构进行营业或者通过设在该缔约国另一方的固定基地从事独立个人劳务，据以支付该利息的债权与该常设机构或者固定基地有实际联系的，不适用第一款、第二款和第三款的规定。在这种情况下，应视具体情况适用第七条或第十四条的规定。

六、如果支付利息的人为缔约国一方政府、其地方当局或该缔约国居民，应认为该利息发生在该缔约国。然而，当支付利息的人不论是否为缔约国一方居民，在缔约国一方设有常设机构或者固定基地，支付该利息的债务与

该常设机构或者固定基地有联系，并由其负担该利息，上述利息应认为发生于该常设机构或固定基地所在缔约国。

七、由于支付利息的人与受益所有人之间或者他们与其他人之间的特殊关系，就有关债权所支付的利息数额超出支付人与受益所有人没有上述关系所能同意的数额时，本条规定应仅适用于后来提及的数额。在这种情况下，对该支付款项的超出部分，仍应按各缔约国的法律征税，但应对本协定其它规定予以适当注意。

第十二条 特许权使用费

一、发生于缔约国一方而支付给缔约国另一方居民的特许权使用费，可以在该缔约国另一方征税。

二、然而，这些特许权使用费也可以在其发生的缔约国，按照该缔约国的法律征税。但是，如果收款人是特许权使用费受益所有人，则所征税款不应超过特许权使用费总额的百分之十。

三、本条“特许权使用费”一语是指使用或有权使用文学、艺术或科学著作，包括电影影片、无线电或电视广播使用的胶片、磁带的版权，专利、专有技术、商标、设

计或模型、图纸、秘密配方或秘密程序所支付的作为报酬的各种款项，或者使用或有权使用工业、商业、科学设备或有关工业、商业、科学经验的情报所支付的作为报酬的各种款项。

四、如果特许权使用费受益所有人是缔约国一方居民，在特许权使用费发生的缔约国另一方，通过设在该缔约国另一方的常设机构进行营业或者通过设在该缔约国另一方的固定基地从事独立个人劳务，据以支付该特许权使用费的权利或财产与该常设机构或固定基地有实际联系的，不适用第一款和第二款的规定。在这种情况下，应视具体情况适用第七条或第十四条的规定。

五、如果支付特许权使用费的人是缔约国一方政府、其地方当局或该缔约国居民，应认为该特许权使用费发生在该缔约国。然而，当支付特许权使用费的人不论是否为缔约国一方居民，在缔约国一方设有常设机构或者固定基地，支付该特许权使用费的义务与该常设机构或者固定基地有联系，并由其负担这种特许权使用费，上述特许权使用费应认为发生于该常设机构或者固定基地所在缔约国。

六、由于支付特许权使用费的人与受益所有人之间或

他们与其他人之间的特殊关系，就有关使用、权利或情报支付的特许权使用费数额超出支付人与受益所有人没有上述关系所能同意的数额时，本条规定应仅适用于后来提及的数额。在这种情况下，对该支付款项的超出部分，仍应按各缔约国的法律征税，但应对本协定其它规定予以适当注意。

第十三条 财产收益

一、缔约国一方居民转让第六条所述位于缔约国另一方的不动产取得的收益，可以在该缔约国另一方征税。

二、转让缔约国一方企业在缔约国另一方的常设机构营业财产部分的动产，或者缔约国一方居民在缔约国另一方从事独立个人劳务的固定基地的动产取得的收益，包括转让常设机构（单独或者随同整个企业）或者固定基地取得的收益，可以在该缔约国另一方征税。

三、转让从事国际运输的船舶、飞机或陆运工具，或者转让属于经营上述船舶、飞机或陆运工具的动产取得的收益，应仅在该企业总机构所在缔约国征税。

四、转让一个公司财产股份的股票取得的收益，该公

公司的财产又主要直接或者间接由位于缔约国一方的不动产所组成，可以在该缔约国一方征税。

五、转让第四款所述以外的其它股票取得的收益，该项股票又相当于缔约国一方居民公司至少百分之二十五的股权，可以在该缔约国一方征税。

六、转让第一款至第五款所述财产以外的其它财产取得的收益，应仅在转让者为其居民的缔约国征税。

第十四条 独立个人劳务

一、缔约国一方居民由于专业性劳务或者其它独立性活动取得的所得，应仅在该缔约国征税。但具有以下情况之一的，可以在缔约国另一方征税：

（一）在缔约国另一方为从事上述活动设有经常使用的固定基地。在这种情况下，该缔约国另一方可以仅对属于该固定基地的所得征税；

（二）在有关历年中在缔约国另一方停留连续或累计超过一百八十三天。在这种情况下，该缔约国另一方可以仅对在该缔约国进行活动取得的所得征税。

二、“专业性劳务”一语特别包括独立的科学、文

学、艺术、教育或教学活动，以及医师、律师、工程师、建筑师、牙医师和会计师的独立活动。

第十五条 非独立个人劳务

一、除适用第十六条、第十八条、第十九条、第二十条和第二十一条的规定以外，缔约国一方居民因受雇取得的薪金、工资和其它类似报酬，除在缔约国另一方从事受雇的活动以外，应仅在该缔约国一方征税。在该缔约国另一方从事受雇的活动取得的报酬，可以在该缔约国另一方征税。

二、虽有第一款的规定，缔约国一方居民因在缔约国另一方从事受雇的活动取得的报酬，同时具有以下三个条件的，应仅在该缔约国一方征税：

（一）收款人在有关历年中在该缔约国另一方停留连续或累计不超过一百八十三天；

（二）该项报酬由并非该缔约国另一方居民的雇主支付或代表该雇主支付；

（三）该项报酬不是由雇主设在该缔约国另一方的常设机构或固定基地所负担。

三、虽有第一款和第二款的规定，在缔约国一方企业经营国际运输的船舶或飞机上从事受雇的活动取得的报酬，应仅在该企业总机构所在缔约国征税。

第十六条 董事费

缔约国一方居民作为缔约国另一方居民公司的董事会成员取得的董事费和其它类似款项，可以在该缔约国另一方征税。

第十七条 艺术家和运动员

一、虽有第十四条和第十五条的规定，缔约国一方居民，作为表演家，如戏剧、电影、广播或电视艺术家、音乐家或作为运动员，在缔约国另一方从事其个人活动取得的所得，可以在该缔约国另一方征税。

二、虽有第七条、第十四条和第十五条的规定，表演家或运动员从事其个人活动取得的所得，并非归属表演家或运动员本人，而是归属于其他人，可以在该表演家或运动员从事其活动的缔约国征税。

三、虽有第一款和第二款的规定，作为缔约国一方居

民的表演家或运动员在缔约国另一方按照缔约国双方政府的文化交流计划进行活动取得的所得，在该缔约国另一方应予免税。

第十八条 退休金

一、除适用第十九条第二款的规定以外，因以前的雇佣关系支付给缔约国一方居民的退休金和其它类似报酬，应仅在该缔约国一方征税。

二、虽有第一款的规定，缔约国一方政府或地方当局按其社会保险制度的公共福利计划支付的退休金和其它类似款项，应仅在该缔约国一方征税。

第十九条 政府服务

一、（一）缔约国一方政府或地方当局对履行政府职责向其提供服务的个人支付退休金以外的报酬，应仅在该缔约国一方征税。

（二）但是，如果该项服务是在缔约国另一方提供，而且提供服务的个人是该缔约国另一方居民，并且该居民：

1、是该缔约国另一方国民；或者

2、不是仅由于提供该项服务，而成为该缔约国另一方的居民，

该项报酬，应仅在该缔约国另一方征税。

二、（一）缔约国一方政府或地方当局支付或者从其建立的基金中支付给向其提供服务的个人的退休金，应仅在该缔约国一方征税。

（二）但是，如果提供服务的个人是缔约国另一方居民，并且是其国民的，该项退休金应仅在该缔约国另一方征税。

三、第十五条、第十六条、第十七条和第十八条的规定，应适用于向缔约国一方政府或地方当局举办的事业提供服务取得的报酬和退休金。

第二十条 教师和研究人员

任何个人是、或者在紧接前往缔约国一方之前曾是缔约国另一方居民，主要是为了在该缔约国一方的大学、学院、学校或为该缔约国一方政府承认的教育机构和科研机构从事教学、讲学或研究的目的，停留在该缔约国一方。

对其由于教学、讲学或研究取得的报酬，该缔约国一方应自其第一次到达之日起，三年内免予征税。

第二十一条 学生和实习人员

学生、企业学徒或实习生是、或者在紧接前往缔约国一方之前曾是缔约国另一方居民，仅由于接受教育、培训的目的，停留在该缔约国一方，其为了维持生活、接受教育或培训的目的停留在该缔约国一方，对其收到或取得的下列款项或所得，该缔约国一方应免予征税：

（一）为了维持生活、接受教育、学习、研究或培训的目的，从该缔约国一方境外取得的款项；

（二）政府或科学、教育、文化机构或其他免税组织给予的助学金、奖学金或奖金；

